

“Учирч болох аюул занал, байгалийн гамшиг, халдварт өвчнийг сөрөн зогсох, дасан зохицох чадвар бүхий Монгол хүнийг хөгжүүлэх” тухай

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн гишүүд “Учирч болох аюул занал, байгалийн гамшиг, халдварт өвчнийг сөрөн зогсох, дасан зохицох чадвар бүхий Монгол хүнийг хөгжүүлэх” тухай Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга Ц.Энхтүвшингээс ирүүлсэн холбогдох баримт материалтай ажлын журмаар танилцаад ЗӨВЛӨМЖ болгох нь:

Нэг. Монгол Улсын Засгийн газарт:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчөөс өгсөн чиглэлийг баримтлан “Учирч болох аюул занал, байгалийн гамшиг, халдварт өвчнийг сөрөн зогсох, дасан зохицох чадвар бүхий Монгол хүнийг хөгжүүлэх” стратегийг боловсруулах ажлын хэсэг байгуулах,

2. Ажлын явцыг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд танилцуулах.

Хоёр. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн даргад:

Стратегийн баримт бичгийн боловсруулалт, цаашдын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.